

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХАЛИУН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИХ

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН
УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

ГҮЙЦЭТГЭГЧ: “ССТ-ОД” ХХК

2024 он

“ССТ-ОД” ХХК

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН
СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН”

ХЯНАСАН:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн БОМТ хариуцсан ажилтан

“ССТ-ОД” ХХК-ийн гүйцэтгэх захирал



Э.Наранбаатар

ТАЙЛАН ГАРГАСАН:

Байгаль орчны мэргэжилтэн

Х.Батсүх

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

АХБ-ны санхүүжилтээр ХХААХҮЯамны захиалгаар хэрэгжиж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх сэргээн засварлах зорилгоор Говь-Алтай аймгийн Халиун сумын нутагт хэрэгжиж байгаа “Ёлтон дэд төсөл” -ийн барилгын ажил гүйцэтгэгчээр “ССТ-ОД” ХХК шалгарч, ХХААХҮЯ-тай 2021 оны 09 сарын 28 өдрийн СW-5-2 тоот хамтран ажиллах гэрээ байгуулсан.

“Ёлтон услалтын систем” төслийн нийт талбай 315 га, барилга угсралтын ажил 2021 оны 3 улирлаас эхэлж 4 жилийн хугацаанд явагдана.

“Ёлтон” услалтын системийн засвар шинэчлэлийн ажлын зургийг “Жишиг Проект” ХХК, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “ГРИЙН НАТУР ЛАНД” ХХК, “НЬЮ ГРИЙН ВОРЛД” ХХК, “ЭКОС” ХХК-иуд хамтран гүйцэтгэж, БОАЖЯ-аар баталгаажуулсан.

2024 оны барилгын ажлын төлөвлөгөөг ХХААХҮЯ, “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслөөр батлуулсан ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төлөвлөгөөг боловсруулж хүргүүлж байна.


1.1 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.


1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ.

“Ёлтон” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь Говь-Алтай аймгийн Халиун сумын нутаг дэвсгэрт байрлана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун урд зүгт 1113 км орчим зайд, Говь-Алтай аймгийн төв Алтай хотоос урд зүгт 120 км-ийн зайд, Халиун сумын төвөөс зүүн зүгт 20 орчим км-ийн зайд оршино. Халиун сум нь баруун талаараа Говь-Алтай аймгийн Төгрөг сумтай, урд талаараа Цээл, Цогт, зүүн талаараа Бигэр, зүүн болон хойд талаараа Есөнбулаг сумдтай тус тус хиллэдэг.

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



ЗУРАГ 1. “ЁЛТОН УСЛАЛТЫН СИСТЕМ” талбайн байршил



ЗУРАГ 2. Тариалангийн талбай

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад
хийгдсэн ажлууд

2.1.1 Барилгын ажилд стандартын шаардлага хангасан элс, хайрга ашиглах

		МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА	
		ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 224102270376	
ТТД / Регистр:	57900826665 / 9016686		
Татвар төлөгчийн нэр:	Говь-Алтай аймгийн Халиун сумын засаг даргын тамгын газар		
Татварын төрөл:	01030709 - Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		
Харьяалах татварын алба:	Говь-Алтай / Халиун		
Төлсөн дүн:	400,000.00 ₮		
Гүйлгээний огноо:	2024-11-27 15:03:23		
Гүйлгээний утга:	224102270376;2116723;;99045533;62000000570;CCT OD XXX;Golomtbank-Online;99045533		
Татварын данс:	Га.Ха Түгээмэл тархацтай АМНАТ - 100051100948		
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк		
			

✓ Стандартын шаардлага хангасан 40 тн элс, хэдэн 40 тн хайргыг Халиун сумын зөвшөөрөгдсөн газраас авч түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 400,000 төгрөгийг орон нутгийн төсөвт төлсөн. /Зураг 3: Төлбөр төлөгдсөн баримт/

2.1.2 Шороон замаар зорчих тээврийн хэрэгслүүдийн хурдыг 30-40 км/цаг-аар хязгаарлах буюу энэ хурднаас хэтрүүлэхгүй байх зохицуулалт хийх

✓ Талбайн инженер тээврийн хэрэгслүүдийг 30км-ээс хэтрүүлэхгүй байх зөвлөмж өгч, ажилчид жолоочид уг зөвлөмжийг даган мөрдөж ажиллаж байна.

2.1.3 Шороон зам дагууд замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж бүхий самбар байршуулж, барилгын ажилчид болон материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүдийг зөвхөн нэг замаар зорчих нөхцөлийг бүрдүүлж, шинээр олон салаа шороон зам үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажиллах.



✓ Тэмдэг тэмдэглэгээг байршуулж, машин механизмууд нэг л замыг ашиглаж байна. Нэг л замыг сонгон ашиглаж байна. Бусад байсан 3 замыг шуудуу татах тэмдэглэгээ тавих зэргээр хаагаад байна.

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1.4 Төслийн талбайг цэвэрлэх үед хуучирч эвдэрсэн бетон байгууламжуудыг зайлуулах, тээвэрлэж хогийн цэгт хаях явцад цаг агаар хуурай үед агаарт тоосжилт үүсэхээс сэргийлэх

- ✓ Төслийн талбайг цэвэрлэх үед хуучирч эвдэрсэн бетон байгууламжуудыг зайлуулан 45 тн хогийг Халиун сумын төвлөрсөн хогийн цэг рүү зөөн хаясан, тоосжилт үүсгэхгүй байхаар алгуурханаар буулгах арга хэмжээ авч ажиллаж байна. Аль болох шинэ хог үүсгэхгүй байхаар ажиллаж байна.

2.1.5 Задгай талбайд овоолох барилгын материалыг газрын гадаргаар тархахаас сэргийлж хаалт, хашилт хийх

- ✓ Задгай талбайд овоолж хураах барилгын материалыг тогтмол хаалт хашлагад байлгаж, бүтээж байсан. /Зураг 4,5-д харуулсан/



Зураг 4,5 :Бороожуулагч машиныг талбайд буулгасан байдал

2.1.6 Барилга, газар шорооны ажлын үед ашиглах хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжинд сайн чанарын түлш ашиглаж агаарт ялгарах хийн төлөвт бохирдуулагчийг багасгах



- ✓ Стандартын шаардлага хангасан сайн чанарын түлшийг МИК ШТС-аас авч талбар дээр нөөцлөн тухайн жилийнхээ хэрэгцээний түлшийг 100тн-ы шатахуун хадгалах саванд хадгалж ашиглаж байна. Савыг байршуулахдаа хөрснөөс ул бетон цутгаж нийлэг хальсаар тусгаарлалт хийгдсэн. Асгарал үүсээгүй болно.

/Зураг 6: 100тн-ы шатахуун хадгалах сав/

2.1.7 Нийт машин механизмуудыг үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай бол хөдөлгүүрийг шинэчилж сайжруулах, хорт утаа ихээр ялгаруулж буй машин техникийг барилгын ажилд ашиглахгүй байх, шаардлагатай үед хаягдал утааг шүүх шүүлтүүр, катализатор хэрэглэх

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ✓ Төслийн хүрээнд самосвал, ачааны машин /50тн/, экскаватор -2ш, унисерсал, ковш, автокран-2ш, ачааны машин /2тн/, индүү, бетон зуурагч зэрэг машин механизмуудыг 4 сард ажил эхлэхийн өмнө үзлэг оношлогоонд хамруулан ажилд гаргахад бэлэн болгон саадгүй ажиллаж байна.

2.2 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бүүрүүлэхэд хийгдсэн ажлууд

2.2.1 Барилгын ажлын үед голын байгалийн үндсэн голдирол, урсцыг өөрчлөх үйл ажиллагаа явуулахгүй байх;

- ✓ Голын голдирлийг өөрчлөлт оруулахгүй байхаар тооцож толгойн барилга руу орох 14 км урттай сувгийг байгуулан голоос усыг татаж толгойн барилга руу орууллаа. Түүнээс цааших усалтын систем рүү орох 4км урттай сувгийг бүрэн засварлан сэргээж усаа шахсан болно.



Зураг 7,8: Толгойн барилгаас ус гаргах болон оруулж шалгаж байгаа байдал

2.2.2 Ахуйн болон барилгын хатуу, шингэн хаягдлын түр цэг, ажилчдын бие засах газрыг усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс гадагш (Уст-Чацран голын эргээс 200 метрээс доошгүй зайд) байрлуулах

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ✓ Ажилчдын бие засах газар **хог түр хадгалах** цэг зэргийг усан сангийн хамгаалалтын бүсээс гадагш 50м зайд байгуулан ашиглаж ирлээ. Мөн 50м-ийн урттай цутгамал зам гаргаснаар тэр хэсгийн газрыг бүрэн хамгаалсан.



Зураг 9: Бие засах газар болон усанд орох боломжтой газрыг бэлэн болгосон байдал

2.2.3 Барилгын ажил явагдах талбаруудад зөөвөрлөн ашиглаж болохуйц био ариун цэврийн байгууламж байрлуулан ашиглах, ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх

- ✓ Төсөл хэрэгжүүлэх хугацаанд талбайгаас 500 м газарт гадагш нүхэн 00-ыг байгуулж ажилчдын хэрэгцээнд ашигласан. Хөрснөөс төмөр бетонон доторлогоотой тусгаарлалт хийсэн. **2025 онд** эко нойл болгон хүлээлгэн өгнө.

2.2.4 Машин техникийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах, шаардлагатай үед засвар үйлчилгээг зориулалтын засварын газарт хийлгэх

- ✓ Компаний засвар үйлчилгээ хариуцсан ажилтнууд машин механизмын ашиглалт техникийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж бага зэргийн эвдрэл гэмтэл гарсан үед зохих үйлчилгээг хийж байлаа. Энэ хугацаанд томоохон ноцтой эвдрэл гэмтэл гараагүй болно.

2.2.5 Услалтын системийн барилга байгууламжууд буюу усан сан, гол суваг, далд сувгийн битүүмжлэлийг стандартын дагуу хийж, шүүрэлт үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх

- ✓ Услалтын системийн барилга байгууламжууд буюу усан сан, 6,4 км урттай гол суваг, 13,6 км урттай далд хоолойн сувгийн битүүмжлэлийг шүүрэлт үүсгэхгүй байдлаар сэргийлж стандартын дагуу хийлээ. Ус хуримтлуулах даланг 200м-ийн урттай 4м-ийн өргөнтэй 1,2м-ээр өндөрлөж төсөвт тусгагдаагүй ажлыг хийж гүйцэтгэсэн.

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



Зураг 10: Ус татамжийн барилгыг, ёроолыг бетонон сууриар доторлож чулуун өрлөгөөр өрж шүүрэлтээс сэргийлж хийсэн байдал.

- ✓ Хуучин хиймэл нуурыг 1979-1981 онд Гуулингийн услалтын системийн контор барьж байгуулсан. Хуучин хиймэл нуурын хонхорыг засаж янзлан ёроолд нь полеталийн хальс тавьж усаар дүүргэж шинээр хиймэл нуур байгууллаа. /1200000м³ ус хуримтлуулах хүчин чадалтай/



Зураг 11: Эвдэрч муудсан ус хуримтлуулах боломжгүй байсан хиймэл нуурыг сэргээн засварлаж, 4метрийн өндөр далан байгуулж ус хуримтлуулав.

2.2.6 Барилгажих талбайн гадна талаар хамгаалалтын зурвас байгуулж, хамгаалалтын зурвас доторх газарт төлөвлөлт, зураг төслийн дагуу үйл ажиллагаа явуулах, тухайн орчимд тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байршуулах

- ✓ Барилга явагдаж буй газрын гадна талаар олон усны системийн зүүн хойно болон зүүн талаар үерээс хамгаалах суваг болон далан хийлээ. Үерээс хамгаалах далангийн өргөн сууриараа 9м, дээд талаараа 6м, өндөр 1,5м харьцаатайгаар байгуулж дуусгалаа.



Зураг 12: Үерээс хамгаалах даланг габион дотор чулуун өргөөр бэхэлж байгаа байдал /далангийн урт сууриараа 9м, дээд талаараа 6м, өндөр 1.5м/

2.3 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд


2.3.1 Нөлөөлөлд өртөөгүй эрүүл талбайг хөндөж хөрс хуулах бол өнгөн хөрсийг тусгай талбайд хадгалж, барилгын ажил дууссаны дараа эвдэрсэн талбайг нөхөн сэргээхдээ ашиглах, аль болох богино хугацаанд олон наст ургамлын үр тарих замаар хөрсийг нөхөн сэргээж элэгдлээс хамгаалах

- ✓ Барилгын ажлын нэг чухал хэсэг учраас талбайн хөрсний гадаргад бүрэн сэргээлт хийлээ. Услалтын системийг Улсын /аймаг, сум/ комисст хүлээлгэж өгсний дараа аймаг сум өөрсдөө хариуцаж малын тэжээл олон наст ургамал тариалж өөрсдийн хэрэгцээг хангана.

2.3.2 Барилгын ажлын үед нэг цэгээс дараагийн цэг рүү шилжих шилжилт тутамд засвар дууссан газрын нөлөөлөлд өртсөн гадаргыг нөхөн сэргээж ухаш, овоолго үлдээхгүй байх, хатуу хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх

- ✓ Барилгын ажлын үед нэг цэгээс дараагийн цэг рүү шилжих шилжилт тутамд засвар дууссан газрын нөлөөлөлд өртсөн гадаргыг ухаж, овоолго үлдээхгүйгээр нөхөн сэргээж, хатуу хог хаягдлыг тухай тухайн үед нь тогтмол түүж цэвэрлэж дуусгалаа. /Зураг 13,14-т ажил хийгдсэн газруудад хог байхгүйг харуулав./

Зураг 13



Зураг 14



**“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд

2.4.1 Барилгын ажлын төлөвлөлт, газар ашиглалтыг зөв хийж ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд байлгах

- ✓ Барилгын талбайн орчимд ургамлын нөмрөгөн бүрхүүлд эмийн болон ховор ургамал байхгүй бөгөөд дан элс хайрга, харгана голлосон хөрстэй газар юм.

2.4.2 Барилгын материал, машин механизмуудыг ургамлан нөмрөг бага буюу аль холбох халцгай газарт байрлуулах, байгалийн ургамалтай газарт барилгын материал буулгах, машин механизмын зогсоол болгон ашиглахгүй байх

- ✓ Барилгын материал, машин механизмуудыг ургамлан нөмрөг бага буюу аль хоосон халцгай газарт байрлуулж, байгалийн ургамалтай газарт байгалийн материал буулгах зэргээр машин механизмын зогсоол болгон ашиглаагүй. Учир нь байгалийн тогтоцын онцлогоос хамаарч ийм ажлын шаардлага гараагүй.

2.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

2.5.1 Барилгажих талбай болон түүний ойр орчимд ямар нэг амьтны төрөл зүйл байгаа эсэх, амьтны үүр, үржлийн дэвсгэр нутаг байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор талбай дээр шалгалт хийх, шалгалтаар эдгээр нөхцөлүүд илэрвэл БОНУ тайлангийн 4-р бүлгийн амьтны аймгийн зөвлөмжийн хэсэгт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх

- ✓ Барилгын орчинд нүдэн баримжаа болон ажиглалтаар голио, царцаа, гүрвэлээс өөр амьтан төслийн хугацаанд ажиглагдаагүй.

2.5.2 Хэрэв барилгын ажлын явцад зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнтэй таарвал үргээлгүй зам тавьж өгөн өнгөрөөж байх;

- ✓ Төслийн ажил хийх явцад ийм шаардлага гараагүй.

2.5.3 Гол суваг, усан санд загас орвол амьдрах орчны хувьд тохиромжгүй тул толгойн барилгад загас орохоос сэргийлсэн тор тавьж гол суваг руу загас орохгүй дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх

- ✓ Голд жараахай байхгүй бөгөөд бичил жижиг амьтад л бий.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БИЕЛЭЛТ

3.1 Услалтын системийн талбай гол суваг дагуу 2 эгнээ, нийт 4800 ширхэг мод тарьж 7.2га талбайд ойн зурвас байгуулах

- ✓ 2024 оны БОМТ-д тусгасан мод тарих ажлыг 9-р сарын дундуур төлөвлөсөн байсан ч гэрээнд нэмэлт өөрчлөлт /бороожуулагч машиныг ажиллуулах цахилгааны ажил ороогүй байсан учраас магадлал хийж батлуулсан/ орсонтойгоор холбоотойгоор 2025 оны БОМТ-д тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

**“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ДӨРӨВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТ

**4.1 Барилга, газар шорооны ажилд хэрэглэх машин механизм, техник тоног
төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байх**

- ✓ Техникийн шаардлага хангасан самосвал, ачааны машин /50тн/, экскаватор -2ш, унисерсал, ковш, автокран-2ш, ачааны машин /2тн/, индүү, бетон зуурагч машин механизмуудад засвар үйлчилгээг тогтмол хийж байсан.

4.2 Бүх ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА-н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг барилгын талбай дээр ажиллуулахгүй байх

MNS 4969:2000

№	Овог нэр	Мэргэжил, зэрэг	Он, сар, өдөр	Хийгдэх ажил	Ходолмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны ерөнхий утга, код	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг	Зааварчилгаа өгсөн хүний албан тушаал, овог нэр, гарын үсэг
1	В.Васильев		01/09	Бүтэцтэй ажил, хамсаа, цуглоо, дагах.	Ич ахуйн ажил, автомашин техник -тэй харьцах үеийн аюулгүй дүртэй.	1. Васильев	М. Хамтбаяр
2	М.Давбаев		01/09			2. Давбаев	М. Хамтбаяр
3	Ц.Тогтоол		01/09			3. Тогтоол	М. Хамтбаяр
4	Т.Доржиев		01/09			4. Доржиев	М. Хамтбаяр
5	Х.Цыды		01/09			5. Цыды	М. Хамтбаяр
6	Б.Хурбат		01/09			6. Хурбат	М. Хамтбаяр
7	А.Амгваа		01/09			7. Амгваа	М. Хамтбаяр
8	В.Цогтбаяр		01/09			8. Цогтбаяр	М. Хамтбаяр
9	С.Хамтбаяр		01/09			9. Хамтбаяр	М. Хамтбаяр
10	А.Тогтоол		01/09			10. Тогтоол	М. Хамтбаяр
11	Васильев		01/10	Төл сувчинг шалгах	Тогор шорооны ажил, машин механизмтай харьцах үеийн аюулгүй дүртэй.	11. Васильев	М. Хамтбаяр
12	Давбаев		01/10			12. Давбаев	М. Хамтбаяр
13	Тогтоол		01/10			13. Тогтоол	М. Хамтбаяр
14	Доржиев		01/10			14. Доржиев	М. Хамтбаяр
15	Цыды		01/10			15. Цыды	М. Хамтбаяр
16	Хурбат		01/10			16. Хурбат	М. Хамтбаяр
17	Амгваа		01/10			17. Амгваа	М. Хамтбаяр
18	Цогтбаяр		01/10			18. Цогтбаяр	М. Хамтбаяр
19	Хамтбаяр		01/10			19. Хамтбаяр	М. Хамтбаяр
20	Тогтоол		01/10			20. Тогтоол	М. Хамтбаяр
21	Васильев		01/11	Төл сувчинг шалгах	—	21. Васильев	М. Хамтбаяр
22	Давбаев		01/11			22. Давбаев	М. Хамтбаяр
23	Тогтоол		01/11			23. Тогтоол	М. Хамтбаяр
24	Доржиев		01/11			24. Доржиев	М. Хамтбаяр
25	Цыды		01/11			25. Цыды	М. Хамтбаяр
26	Хурбат		01/11			26. Хурбат	М. Хамтбаяр
27	Амгваа		01/11			27. Амгваа	М. Хамтбаяр
28	Цогтбаяр		01/11			28. Цогтбаяр	М. Хамтбаяр
29	Хамтбаяр		01/11			29. Хамтбаяр	М. Хамтбаяр
30	Тогтоол		01/11			30. Тогтоол	М. Хамтбаяр

- ✓ Технологийн шат дамжлага бүрт ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсгийг авч ажиллаж байсан.

Зураг 15: Ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н зааварчилгаа өгсөн бүртгэл

4.3 Барилгын материал ачиж буулгах, өргөх зэрэг эрсдэлтэй алхмуудыг ХАБЭА-н инженерийн хараа хяналтанд гүйцэтгэх ба аюулгүй байдлын ажилтан шаардлагатай тохиолдолд зааварчилгаа өгөх

- ✓ Төслийн хугацаанд ХАБЭА-н инженер хүн тус бүрд заавар зөвлөгөө өгч анхаарулан ажилласан тул ямар нэгэн осол аваар зөрчил гараагүй болно.

4.4 Цаг агаарын аюулт үзэгдэл болж болзошгүй сэрэмжлүүлэг зарласан өдрүүдэд бүх ажилчдад дүүлган, сонор сэрэмжтэй ажиллахыг сануулах, аян замд гарахгүй байх, төслийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх, онцгой тохиолдолд ажиллуулахгүй байх арга хэмжээ авах

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ✓ Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай борооны үед анхаарал болгоомжтой байхыг тогтмол сануулж тухай үед нь зохион байгуулан хэрэгжүүлж байсан. Онц аюултай үед ажлаа түр зогсоох арга хэмжээг авч байсан.



Зураг 16: Ажил хийгдээж байх үед шороон шуурга эхэлж ажил түр зогсоох тухай арга хэмжээг ажилчдад хэлж байгаа байдал.

4.5 Ургамал хамгааллын бодисуудыг стандартын шаардлага хангасан 2 тасалгаа бүхий агуулах байгуулж хадгалах, бодисуудыг хор аюулын ангилалаас нь хамаарч ангилан ялгаж хадгалах

- ✓ Стандартын шаардлага хангасан 2 тасалгаа бүхий агуулах барьж бэлэн болгосон. Одоохондоо ургамал хамгааллын бодисыг аваагүй байгаа бөгөөд уг системийг ашиглалтад өгөх үед төсөлд тусгасны дагуу шаардлагатай бодисыг авч сум орон нутагт хүлээлгэн өгнө.



Зураг 17: Зураг төсөвт тусгагдсан стандартын шаардлага хангасан агуулахыг барьж бэлэн болгосон байдал.

ТАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТ

5.1 Барилгын ажил явагдах талбайд ахуйн хатуу хог хаягдлыг хуримтлуулах

- ✓ 2 цэгт байршуулан ашиглаж байна.



Зураг 18: Хатуу хог хаягдлыг хуримтлуулах сав хийж байгаа байдал.

5.2 Барилгын талбайн орчимд үүссэн хатуу хаягдлыг зориулалтын үүт саванд хийж, ажил дууссаны дараа түр цэгт ялган хийх

- ✓ Нягтаршуулах зориулалт бүхий “хаягдал пресслэгч машин” -ыг авч бэлэн болсон байна.

5.3 Дахин боловсруулах боломжгүй ахуйн хаягдлыг сард нэг удаа сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт зөөвөрлөх

- ✓ Энэ асуудлыг сумын төв дээр байрлах дагавар бүтээгдэхүүн авах цэгтэй ярьж тохироод байна.

5.4 Нэг удаагийн ахуйн хэрэглээнээс татгалзах буюу нэг удаагийн аяга таваг болон бусад зүйлсийг огт хэрэглэхгүй байх, ахуйн хэрэглээний материалыг аль болох олон удаа ашиглах байдлаар үүсэж болох хаягдлыг бүүрүүлэх

- ✓ Манайх хоолны зөвхөн байнга хэрэглэгдэх шил шаазан, төмөр аяга таваг, халбага сэрээ ашиглаж байна.

ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Усны шинжилгээг толгойн барилгад ус татаж буй голоос, усны системн талбай дахь гүн өрмийн худгаас тус тус авч шинжилгээ хийлгэлээ. Дээж авч битүүмжилсэн лабораторын голын усны эхний шинжилгээний дүнгээс үзэхэд кальци \100мг/л-аас ихгүй \ 31.0, Магний \30.0мг/л-ээс ихгүй\ 21.0, Нийт төмөр \0.3мг-л-ээс ихгүй\ 0.3, Нитрат 50мг-л-ээс ихгүй 7.0, Нитрит 1.0мг/л-ээс ихгүй 0.03, рН \6.5-8.5\ 7.4, Сульфат 500мг-л-ээс ихгүй 155.0, Хатуулаг 7.0мг/л-ээс ихгүй 3.0, Хлорид 350мг/л-ээс ихгүй 21.0, Хуурай үлдэгдэл 1000мг/л-ээс ихгүй 600.0, талбайн усны шинжилгээнээс харахад кальци \100мг/л-аас ихгүй \ 96.2, Магний \30.0мг/л-ээс ихгүй\ 43.2, Нийт төмөр \0.3мг-л-ээс ихгүй\ 0.2, Нитрат 50мг-л-ээс ихгүй 25.2, Нитрит 1.0мг/л-ээс ихгүй 0.0, рН \6.5-8.5\ 7.8,

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сульфат 500мг-л-ээс ихгүй 166.1, Хатуулаг 7.0мг/л-ээс ихгүй 5.75, Хлорид 350мг/л-ээс ихгүй 54.4 тус тус байна.

Шинжилгээний дүнгээс үзэхэд байгалын голын усан бохирдоогүй усанд байвал зохих химийн элемент хэвийн хэмжээнд байгаа нь харагдаж байна. Услалтын системийн дэргэдэх 120метрээс гаргасан гүн өөрмийн худгийн бичил биетний шинжилгээний дүн нь ББЕТ \1мл-т 100-аас бага\ 20ш, *Salmonella spp* \100мл-т илрэх ёсгүй\ илрээгүй, байгаа нь хүсний эрүүл ахуйн стандартын шаардаглас нийцэж байна. Тус лаборид *E.coli*-н шинжилгээ хийх бодис байхгүй учир энэ удаад гаргаагүй болно.

Хөрсний шинжилгээг услалтын системийн талбайн урд, хойно, баруун, зүүн, төв гэсэн 5 хэсгээс авсан. Итгэмжилэгдсэн лабораторын хими физикийн бодисын шинжилгээгээр: *Clostridium perfringens* \Илрэх ёсгүй\ Илрээгүй. Эмгэгтөрөгч нян \Илрэх ёсгүй\ Илрээгүй.

Бүх дээж авсан хэсгүүдээс ямар нэгэн бодис илрээгүй байна. Энэ нь талбайн хөрсөнд байх ёстой элементүүд хэвийн байгаа ба ямар нэгэн сөрөг зүйл илрээгүй байна.

ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1 БОМТ-ийн төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулан эрх бүхий байгууллагаар баталуулах тайлагнах 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалаар батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсруулж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамаар батлуулан ажилласан.

7.2 Мониторингийн цэгийг байгуулах цооног өрөмдөх зөвшөөрөл Говь-Алтай аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраас авахаар 2025 оны төлөвлөгөөнд тусгасан байна.

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

8.1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах ажлын хүрээнд 2024 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг eis.mn сайтаар илгээж [Говь-Алтай аймгийн Байгаль орчны газарт](#) хүргүүлээ.



Зураг 19



Зураг 20



Зураг 21

Зураг 19,20,21: Сум багийн иргэдэд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хийсэн ажлын тайланг танилцуулж байгаа байдал

“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Гэрээний нэмэлт өөрчлөлттэйгээр холбоотой гадна цахилгааны ажил нэмэгдсэн.

Гадна цахилгааны ажлыг 2024 оны 10-р сарын 20-оос 11-р сарын 06-ны хооронд 60х60х2,20м гүнтэй шонгийн нүх ухаж 34ш шон суулгасан. Цахилгааны утас татан хийж гүйцэтгэсэн. Шонгийн нүх ухсан хөрсөө буцаан булалт хийж хэвийн байдалд оруулсан.



Зураг 22: Шонгийн нүх ухсан байдал



Зураг 23: Шон суулгаж байгаа байдал



Зураг 24: Кабель утас, газардуулгын шин татахад нүх ухсан байдал



Зураг 25: Шон суулгаж утас татаж дууссаны дараа ухсан нүх шороог хэвийн байдалд оруулсан нь



Зураг 26: Шон суулгаж утас татаж дууссаны дараа ухсан нүх шороог хэвийн байдалд оруулсан нь

**“ЁЛТОН ДЭД ТӨСЛИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Гол сувгийн эвдэрч угаагдсан хэсгийг цементэн зуурмагтай чулуун өрлөгөөр бэхлэж, сувагт хуримтлагдсан элс шороог бүрэн цэвэрлэсэн. Төвийн эргэлттэй 5ш бороожуулагч машин суурилагдахаас гурван ширхэгийг нь өмнөх онд суурилуулсан бөгөөд үлдсэн хоёрыг суурилуулж төв шугамтай холбох угсрах ажил дуусч бороожуулагч машиныг иж бүрэн угсарч, суурилуулсан. Төсөл хэрэгжих бүс нутаг нь хуурай уур амьсгалтай говийн бүс нутаг бөгөөд гадаргын усан сүлжээ, усны нөөц бага тул цаашид гол сувгийн дагууд болон усан санг тойруулан ойн зурвас байгуулж усны ууршилтыг багасгах арга хэмжээ авахаар төлөвлөснөөс 2000ш модыг бэлэн авч перховлэж өвөлжуулж багцлан тарилтад шилжүүлнэ. Үлдэх 2800 модыг Говь-Алтай аймаг, Халиун сумын аж ахуй нэгж иргэдээс авахаар тохироод байна. 2025 оны 6 сарын 1-ны дотор сувгийг бүрэн ашиглалтад оруулж 4800ш модыг бүрэн тарьж усан ашиглан тордож услалтын системийг хүлээлгэн өгөх үед Халиун суманд албан ёсоор хүлээлгэн өгнө. Халиун сум нь Алтай-Улиастай эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 2009 онд баригдсан 15 квт-ын дэд станцтай. 87 км цахилгаан дамжуулах агаарын шугамтай. Энэхүү ЦДАШ-аас услалтын системийн талбайн цахилгаан эрчим хүчийг хангахаар шинээр зураг төсөв хийгдсэн ажлын 62%-ийг 2024 онд хийж гүйцэтгээд байна. Үерийн хамгаалалтын 3300 м урттай суваг, 1400м урттай далан сэргээн засварлаж байгааг гүйцээж нягтруулж ашиглалтад өгөхөөр бэлэн болгосон. Услалтын системийн талбайг тойруулан нийт 8.9 км урт торон хашаа баригдахаас бүрэн хийж ашиглалтад ороод байна. Торон хашаа 6 эгнээ зэвэрдэггүй ган утастай, модон шонтой байна. Ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах зорилгоор талбайн шороон замыг хувиарлах ба усалгааны далд хоолойн дагууд байхаар төлөвлөгөөнд тусгаж 2024 онд ашиглалтад өгөхөөр тусгасан боловч гэрээний хугацаа сунгагдаж 2025 он болсон тул улсын комисс ажилахаас өмнө хийж хүлээлгэн өгнө. /Замын өргөн $b=6.5$ м, нийт урт нь 2.4 км./



Ажиллах горим: Барилга угсралтын ажлыг 2025 оны 05-р сарын 01-нээс эхлэн 8-р сарын 15-ны хооронд бүрэн дуусгаж Улсын коммист хүлээлгэн өгөхөөр төлөвлөв.